

**ГОВИЙН БАЙГАЛЬ, ТҮҮХИЙН МУЗЕЙН 2025 ОНЫ СҮҮЛИЙН
ХАГАС ЖИЛИЙН ДОТООД ХЯНАЛТЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 17

Даланзадгад сум

Байгууллагын дотоод хяналтын ажлын хэсгийн 2025 оны төлөвлөгөөнд 2 чиглэл, салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, байгууллагын дотоод журам, менежмент, ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, өмнөх дотоод хяналтын шалгалтаар өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт хийж ажиллалаа.

Нэг. Музейн хууль тогтоомж, дүрэм журам, МУ-ын стандартын чиглэлээр хяналт хийхэд:

- Байгууллагын ёс зүйн дэд хороо 2025 онд 6 ажил төлөвлөн цахим системд байршуулан ажлыг тайлагнан үр дүнтэй ажиллаж байна. 2025 онд Ёс зүйн дэд хороонд өргөдөл гомдол санал ирээгүй бөгөөд 28 албан хаагч ёс зүйн ямар нэгэн зөрчилгүй ажилласан байна. Музейн ёс зүйн хороо нь дарга, нарийн бичиг, гишүүн гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Энэ онд “Ёс зүйн тухай хууль”, Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл бүхий 18 хуудас эмхэтгэл боловсруулж гарын авлага болгон өгсөн байна.
- Музей нь мэдлэг мэдээлэл түгээх, техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байдал – үзүүлэгийн танхимуудад дэлгэцээр видео танилцуулга 6 ш, богино хэмжээний танин мэдэхүйн кино 2 –ыг үзэгчдэд хүргэж олны хүртээл болсон байна.
Сүүлийн хагас жилд Аудио хөтөч тайлбарын 2 төхөөрөмж, 10 чихэвч авсан ба үзэгчдэд хүргэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- Музейн цуглуулгын катологи, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном 2025 онд “Нүүдэлчдийн өв судлал” сэтгүүлд өгүүлэл 2 удаа, Музейн сан хөмрөг, үзүүлэг дэхь уран зургуудаар катологи ном хэвлэлтэд өгсөн байна. Тун удахгүй шинэ ном уншигчдад хүрнэ.
- Сан хөмрөг, Музейн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа соёлын биет ба биет бус өвийн бүртгэл маягтуудыг эмхлэн цэгцэлж товьёогжуулан байгууллагын архивт хүлээлгэн өгч дээд шатны байгууллагын шалгалтад амжилттай орсон байна.
- Сүүлийн хагас жилд 21 төрлийн музейн боловсрол, олон нийтийн ажлыг удаа зохион байгуулж 2857 хүүхэд багачуудыг хамруулж түүх, соёлын өвийн мэдлэгийг дээшлүүлсэн байна.
- 2025 онд музейн сан хөмрөгийг баяжилтийн тоо мэдээ:

№	Үзмэрийн нэр	Тоо ширхэг	Төрөл зүйл
1	Батмөнх даян хаан	1	Урлаг уран сайхан
2	Жасрай гэгээнтэн	1	Шашин
3	Төмөр хавх	3	Угсаатан
4	Гуулин том данх	1	Угсаатан

5	Цутгамал шатар	1	Урлаг уран сайхан
6	Чингис хаан задгай утсан хатгамал	1	Урлаг уран сайхан
7	Байгалийн үзмэр	27	Байгаль
8	Тогтох даргын одон медаль	1	Түүх
9	Тогтох даргын дээл	1	Түүх
10	Тогтох даргын бүс	1	Түүх
11	Тогтох даргын сампин	1	Түүх
12	Тогтох даргын зургийн аппарат	1	Түүх
		Нийт 40	

Үзмэрийн төрөл чиглэлээр ангилвал:

Урлаг уран сайхан-3ш, Шашин-1ш, Угсаатан-4ш, Түүх-5ш, Байгаль-27ш байна.

- Музейн үзмэр цуглуулгын бодлогын баримт бичгийг эрдэм шинжилгээний ажилтан Д.Цэндээр ахлуулсан баг ажиллаж музейн захиргаанд танилцуулж батлуулав. Бодлогын баримт бичиг нь 5 бүлэг 16 зүйлээс бүрдсэн байна.
- Говийн байгаль, түүхийн музей нь музейн стандарт бүхий тайлбар танилцуулгыг үе шаттайгаар бэлтгэн үзэгчдийн хүртээл болгосон. Танхимын, сэдэвчилсэн, нэгж үзмэрийн гэх мэт төрлүүд байдаг байна.
- 2025 онд Аймаг байгуулагдсан түүх, геологи, урлаг уран сайхан, шашны танхимын үзмэрүүдийн хаяг тайлбарыг крилл, монгол бичиг, англи хэл дээр 65 ш үзмэрийг хаягийг шинэчлэн бичиж байршуулсан байна.
- Эд хөрөнгийн сүүлийн хагас жилийн дотоодын тооллого музейн захирлын тушаал гарсан боловч хараахан тоолж амжаагүй байна.
- Байгууллагын ил тод байдлын талаарх ажлыг аймгийн бүртгэл мэдээллийн санч Х.Уянга хариуцан ажиллаж байна. Үүнд: Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу хэрэгжиж буй “Шил ажиллагаа” хэмээх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх маягтын дагуу асуулгыг бөглөж “shilen.gov.mn” нэгдсэн системд илгээж ажилласан байна.
- Байгууллагын дотоод журмын хэрэгжилт: Хөдөлмөрийн дотоод журмын 7.9дэхь заалтыг үндэслэн музейг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнуулсан 5 ажилтанд цалингийн 20% ийн мөнгөн шагналыг олгосон байна.
Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.11.10.13 дахь заалтуудыг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарч байгаа харуул Ц.Жаргалбат, байгалийн музейн ажилтан Д.Гэрэлмаа нарт мөнгөн урамшуулал (400.0-600.0) , үйлчлэгч Ш.Нарантуяад шинэ гэр барьсантай холбогдуулан 400.0 төгрөгний дэмжлэг олгосон байна.
- II улирлын үр дүнгийн урамшууллыг ХДЖурмын 7.5, 7.8 дахь хэсгийг үндэслэн 24 ажилтанд өгсөн байна.
Музейн 7 ахмадад ахмадын баяраар ХДЖурмын 7.10.11 мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.
- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хүрсэн үр дүнг Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7-дугаар

хавсралтын дагуу албаны дарга нар үнэлэн, дараа нь төсвийн шууд захирагч үнэлэн дүгнэж хэвшсэн ба хамт олны үнэлгээг цахимаар нууц санал хураалтаар авч дүгнэсэн ба ажилтнууд (6,4 -7,4) үнэлэгдсэн байна.

- Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр: 2025 музейн ажилтнууд нийт 41 сургалтанд хамрагдсан байна. Үүнээс мэргэжлийн сургалт 10, аймаг орон нутггаас болон туршлага судлах сургалт 31 ба танхимаар 30 сургалт, цахимаар 11 сургалт байна.

Музейн захиргаанд нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр:

- Оюутан сурагчтай 3 албан хаагч
- Барилга байгууламжид дэмждэг хүссэн 2 албан хаагч
- Өрх толгойлсон – 1 албан хаагч
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй - 1 албан хаагч
- Сувилалд хэвтэх-3 албан хаагчдын өргөдөл гомдлыг бүртгэж зохих хэмжээгээр шийдвэрлэсэн байна.

Хоёр. Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн чиглэлээр:

1. “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд нийт 4 албан хаагчийг байгууллагаас дэмжлэг хүсэлтийг, баримт бичгийг бүрдүүлэн өгч шийдвэрлүүлсэн байна.

2 албан хаагч нь магистр, докторын сургалтын төлбөр, 2 нь шинэ хувийн орон сууцаа барьж дуусгах дэмжлэг авсан байна.

“Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Музейн боловсролын ажлын хэрэглэгдэхүүнд зориулж 2 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоол, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны сайдын тушаал, Аймгийн засаг даргын захирамжийн дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг 2025 оны 10-р сарын 01-ний өдрөөс музейн үзмэрийн тооллого эхэлсэн. Одоогийн байдлаар Хөдлөх дурсгалын улсын тооллогын ажил 85 хувьтай явагдаж байна. Орон нутгийн судлах танхимуудын тооллогын ажил бинзен ховор байгаагийн улмаас хойшлогдоод байна.

Жич: Бусад заалтуудын хэрэгжилтийг ПП-ээр бичсэн болно.

ДҮГНЭЛТ:

Байгууллагын 2025 оны сүүлийн хагас жилийн дотоод хяналтыг ил тод болон шударга бодитой байх зарчим дээр тулгуурлан холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалт хийж, үр дүнг тооцон ажиллалаа. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 99.5% -тай хэрэгжиж дээд газарт хүргүүлсэн байна.

Музейн боловсрол, олон нийтийн ажлыг хангалттай зохион байгуулж байгаа хэдий ч оролцох хамрагдах хүний тоо дутмаг байгаа нь харагдлаа. Иймээс хугацааг оновчтой төлөвлөх, олон ажил төлөвлөх бус үр дүнтэй, хүртээмжтэй ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг ажил үүргийг зохицуулан хангалттай хэмжээнд шийдэж байгаа нь харагдлаа.

Байгууллагын уур амьсгалд сайнаар нөлөөлөх хүчин зүйлс ихэнх ажилтнууд эерэг харилцаа хандлага, удирдлага, ажилтнуудын ёс зүй гэсэн байна. Ажилтнуудын харилцаа хандлагын үнэлгээг цахимаар явуулахад шударга үнэлгээ гарсан гэж үзэж байна.

Баримт бичиг боловсруулах, стандартын талаарх мэдлэг дунд түвшинд байна гэж дүгнэлээ. Баримт бичгийн бүрдэл, стандарт, албан хэрэг хөтлөхтэй холбоотой дүрэм журмын талаар архив, бичиг хэргийн эрхлэгчийн сургалтыг дахин авах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна. Байгууллагын дотоод хяналтын ажлын тайлан, дүгнэлтийг хамт олонд танилцуулж хэвшсэн байна. И оффисд музейн нарийн бичиг хяналтанд авах шаардлагатай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн авч, удирдлагад танилцуулж, хариуцах албан тушаалтанд эзэнжүүлж биелэлтийг мэргэжилтнүүд оруулж хэвшиж байгаа нь саашаалтай.

Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа нь байгууллагын дотоод хяналтын багийн ажил үр дүнтэй сайн ажиллаж байгаа гэж дүгнэж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТЫН БАГИЙН АХЛАГЧ

Л.БОЛОРМАА

